



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.05.16 № 02/МҮ-ГАГСОД/02

Хөрөнгө оруулалтын төсөл, арга
хэмжээг хэрэгжүүлэх тухай

БАТЛАН ХАМГААЛАХ
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА
Б.БОЛДБААТАР ТАНАА

“Улсын төсвийн хөрөнгөөр 2012 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн аудитаар тус яам 2012 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын 15.9 тэрбум төгрөгийн 19 төсөл, арга хэмжээнээс 1 төсөл, Тэмүүжин өрлөг дунд сургуулийн барилгын ажил 1246.8 сая төгрөгийн санхүүжилт авсан боловч ажлын гүйцэтгэл дутуу, мөн Бага баянд баригдсан 2.8км авто зам урьд хийгдсэн байсан бөгөөд тендер зарлан 735.0 сая төгрөгийн санхүүжилт өгсөн зөрчил, дутагдал илэрлээ.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 27-ны 290 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”-ын 3.15, 5.3, 5.5-д заасныг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т “Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх ...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1-д “... алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэсэн заалтыг үндэслэн ШААРДАХ НЬ:

Аудитаар илэрсэн зөрчлийг бүрэн хэрэгжүүлж, биелэлтийг гарган 2013 оны 09 дугаар сарын 31-ний ирүүлэхийг даалган албан шаардлага хүргүүлж байна.

Албан шаардлага бичсэн:

ҮАГ-ын Ахлах аудитор



Д.Баттулга